



111

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Улс, нийслэл, орон нутгийн өмчийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй барилга байгууламжийн угсралт, засварын ажлуудын хэрэгжилтийн явц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаж буй байдалд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, төсөл арга хэмжээнд хяналт тавих ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Энэ тушаал гарснаар газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/46 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б. МӨНХБАТ

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын
Даргын 2021 оны 06 сарын 15-ны өдрийн
2/32 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

д/д	Дүүргийн нэр	Ерөнхий хяналт тавих	Хяналт тавих
1.	Сонгинохайрхан дүүрэг	Х.Батхүү – Хуулийн асуудал хариуцсан орлогч дарга	Б.Ганзориг Б.Туяажаргал Э.Баярмагнай А.Алтантулга Х.Ариунчимэг Д.Золжаргал С.Ариунтуул
2.	Баянгол дүүрэг		Б.Лхагважав Г.Мөнх-Эрдэнэ Д.Золжаргал Э.Баярмагнай У.Одгэрэл С.Ариунтуул
3.	Хан-Уул дүүрэг	Ш.Алтангэрэл – Захиргааны асуудал хариуцсан орлогч дарга	С.Соёмбо Г.Ганпүрэв Х.Энхбаясгалан Э.Оргил У.Одгэрэл Х.Наранцэцэг
4.	Чингэлтэй дүүрэг		С.Цэдэнсодном А.Баасансүрэн Х.Наранцэцэг Э.Оргил У.Одгэрэл Х.Энхбаясгалан
5.	Сүхбаатар дүүрэг		С.Соёмбо Ч.Баярхүү Х.Энхбаясгалан Э.Оргил У.Одгэрэл Х.Наранцэцэг
6.	Баянзүрх дүүрэг	А.Хаянхярваа – Төлөвлөлтийн асуудал хариуцсан орлогч дарга	Ц.Алтангэрэл Б.Туяажаргал Р.Дамбадаржаа Б.Энхбаатар Н.Энхбаяр Э.Намуунмөрөн
7.	Багахангай дүүрэг		Ш.Саранчимэг Г.Дэлгэрсайхан Н.Энхбаяр Б.Энхбаатар У.Одгэрэл
8.	Багануур дүүрэг		Н.Эгиймаа Х.Хонгорзул Р.Дамбадаржаа Г.Дэлгэрсайхан Б.Энхбаатар У.Одгэрэл
9.	Налайх дүүрэг		Н.Эгиймаа Н.Энхбаяр Г.Дэлгэрсайхан Б.Анхбаяр Б.Энхбаатар У.Одгэрэл



Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын
Даргын 2021 оны 06 сарын 15-ны өдрийн
А/32 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ХЯНАЛТ ТАВИХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

2021 оны улс, нийслэл, орон нутгийн өмчийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй барилга байгууламжийн угсралт, засварын ажлуудын хэрэгжилтийн явц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаж буй байдалд хяналт шалгалт хийх, төсөл, арга хэмжээнд хяналт тавих, ажлыг эрчимжүүлэх, гэрээний хугацаанд ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахад удирдамжийн зорилго оршино.

Хоёр. Зохион байгуулалт

- 2.1. Орлогч дарга нар хуваарийн дагуу дүүргүүдийг хариуцаж ажиллана. Үүнд:
 - Захиргааны асуудал хариуцсан орлогч дарга Ш.Алтангэрэл - Төвийн бүс буюу Хан-уул, Чингэлтэй Сүхбаатар дүүрэг
 - Хуулийн асуудал хариуцсан орлогч дарга Х.Батхүү - Баруун бүс буюу Баянгол, Сонгинохайрхан дүүрэг
 - Төлөвлөлтийн асуудал хариуцсан орлогч А.Хаянхярваа - Зүүн бүс буюу Баянзүрх дүүрэг, Багахангай, Багануур, Налайх дүүрэг
- 2.2. Төсөл, арга хэмжээнд хяналт тавих ажлын хуваарийг Барилга захиалагчийн хэлтэс 14 хоногт 1 удаа гаргаж газрын даргаар батлуулна.

Гурав. Хугацаа

3.1. Хяналтын ажил нь төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн угсралт, засварын ажил дуусч, байнгын ашиглалтад орох хүртэл үргэлжилнэ.

Дөрөв. Тайлан

- 4.1. Ажлын явцыг 7 хоног бүрийн Даваа гарагт газрын шуурхай хуралд танилцуулна.
- 4.2. Төсөл, арга хэмжээ цаашид хэрэгжих боломжгүй, тасалдсан, зогссон тохиолдолд шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн тухайн тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид болон нийслэлийн Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллана.